Дэрхийг гэрчилж зохих ёсоор эрх олгогдсон оролцогч улсуудын дор дурдсан төлөөлөгчид энэхүү конвенцод гарын үсэг зурав.

Энэхүү конвенцыг нэг мянга есөн зуун ерэн есөн оны 5 дугаар сарын 28-ны өдөр Монреаль хотноо англи, араб, хятад, франц, орос болон испани хэлээр байгуулсан бөгөөд бүх эх бичвэр нь адил хүчинтэй байна. Энэхүү конвенцын эхийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын архивд хадгалах бөгөөд Конвенцын эх хадгалагч нь уг конвенцын баталгаатай хуулбарыг түүний оролцогч бүх улс, мөн түүнчлэн Варшавын конвенц, Гаагын протокол, Гуадалахарагийн конвенц, Гватемала хотын протокол болон Монреалийн протоколын оролцогч бүх улсад хүргүүлнэ.

161. АГААРЫН ХАРИЛЦААНЫ ДАМЖИН ӨНГӨРӨХ ОЛОН УЛСЫН ХЭЛЭЛЦЭЭР

1944 оны 12 дугаар сарын 7-ны өдөр баталж,
1945 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр өдөр хүчин төгөлдөр болсон[*]

Олон улсын иргэний нисэхийн байгууллагын гишүүн болох улсууд энэхүү Агаарын харилцааны дамжин өнгөрөх олон улсын хэлэлцээрт гарын үсэг зурж, түүнийг хүлээн зөвшөөрснөөр дараах зүйлийг мэдэгдэж байна. Үүнд:

1 дүгээр зүйл
1 дэх хэсэг

Хэлэлцэн тохиролцогч аль ч улс олон улсын агаарын хуваарьт үйлчилгээтэй холбоотойгоор нислэгийн дараах агаарын эрхийг хэлэлцэн тохиролцогч нөгөө улсуудад олгоно. Үүнд:

(1) өөрийнх нь нутаг дэвсгэр дээгүүр буухгүйгээр нисч өнгөрөх давуу эрх;
(2) хөдөлгөөний бус зориулалтаар буух давуу эрх.

Олон улсын агаарын хуваарьт үйлчилгээ үзүүлэхээс бусад тохиолдолд энэ хэсэгт заасан давуу эрхүүд нь цэргийн зориулалтаар ашиглагдаж буй нисэх буудлын хувьд үйлчлэхгүй. Байлдааны ажиллагаа, эсхүл цэргийн эзлэн түрэмгийлэл явуулж буй нутаг дэвсгэрт, эсхүл ийм нутаг дэвсгэрт хүрэх агаарын замналын дагуу дайнтай байгаа нөхцөлд дээрх давуу эрхийг цэргийн эрх бүхий этгээдийн зөвшөөрлийн дагуу хэрэгжүүлнэ.

2 дахь хэсэг

Дээр дурдсан давуу эрхийг Чикаго хотноо 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдөр тус тус гарын үсэг зурсан Олон улсын иргэний нисэхийн түр хэлэлцээр болон Олон улсын иргэний нисэхийн конвенц хүчин төгөлдөр болмогц уг конвенцын заалтуудтай нийцүүлэн хэрэгжүүлнэ.

3 дахь хэсэг

Хэлэлцэн тохиролцогч нөгөө улсын нисэх компанид хөдөлгөөний бус зориулалтаар зогсолт хийх давуу эрх олгосон хэлэлцэн тохиролцогч нөгөө улс нь ийнхүү зогсолт хийх цэгүүдэд зохих төлбөрт үйлчилгээ үзүүлэхийг уг нисэхийн компаниас шаардаж болно.

Дээрх шаардлагыг тавихад агаарын нэг замналд үйл ажиллагаа явуулж буй нисэх компаниудыг ямар нэг байдлаар хооронд нь ялгаварлан гадуурхаж болохгүй бөгөөд агаарын хөлгийн хүчин чадлыг харгалзан үзэх, эсхүл тавьж буй уг шаардлага нь олон улсын

[*] Монгол Улс 2004.04.15-нд соёрхон баталсан

агаарын үйлчилгээ үзүүлэгчийн хэвийн ажиллагаа болон хэлэлцэн тохиролцогч улсын эрх үүргийг аливаа байдлаар хөндөх ёсгүй.

4 дэх хэсэг

Энэхүү хэлэлцээрт заасны дагуу хэлэлцэн тохиролцогч аль ч улс:

(1) Өөрийнх нь нутаг дэвсгэр дээгүүр олон улсын аливаа агаарын үйлчилгээ үзүүлэх агаарын замнал болон ийнхүү агаарын үйлчилгээ үзүүлж болох нисэх буудлыг тогтоож болно;

(2) Уг нисэх буудал буюу бусад тоног төхөөрөмж ашигласны төлбөрийг үндэслэлтэйгээр, эсхүл хямдаар тогтоох, эсхүл ийнхүү тогтоохыг зөвшөөрч болох бөгөөд эдгээр төлбөрийн хэмжээ нь тухайн улсын агаарын дотоодын хөлөгт олон улсын ижил төстэй үйлчилгээ үзүүлэх нисэх буудал болон бусад тоног төхөөрөмжийг ашиглуулсны хувьд төлөх төлбөрийн хэмжээнээс илүү байж болохгүй. Ийнхүү нисэх буудал болон бусад тоног төхөөрөмжийг ашигласны төлбөрийн хэмжээг сонирхогч хэлэлцэн тохиролцогч улсаас хүсэлт гаргасны үндсэн дээр дурдсан конвенцын дагуу байгуулагдсан Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Зөвлөл хянаж холбогдох улс буюу улсуудаар хэлэлцүүлэхээр тайлан бэлтгэж, зөвлөмж гаргана.

5 дахь хэсэг

Хэлэлцэн тохиролцогч аль нэг улс нөгөө улсын агаарын тээврийн байгууллагын эзэмшигч нь эрх мэдлийн хувьд хангалтгүй, эсхүл хэлэлцэн тохиролцогч тухайн улс явуулж буй үйл ажиллагаанд нь үр ашигтай хяналт тогтоож чадахгүй, эсхүл агаарын тээврийн уг байгууллага нь нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулж байгаа улсынхаа хууль тогттоомжийг биелүүлээгүй, эсхүл энэхүү хэлэлцээрт заасан үүргийг биелүүлээгүй нөхцөлд уг байгууллагад олгосон гэрчилгээ буюу зөвшөөрлийг хураан авах, эсхүл хүчингүй болгох эрх эдэлнэ.

2 дугаар зүйл
1 дэх хэсэг

Хэлэлцэн тохиролцогч аль ч улс нь хэлэлцэн тохиролцогч нөгөө улсаас энэхүү хэлэлцээрийн дагуу явуулж буй үйл ажиллагаа нь шудрага бус, эсхүл хүндрэл учруулж байна гэж үзвэл байдлыг шалгуулахаар Зөвлөлд хүсэлт гаргаж болно. Зөвлөл нь уг хүсэлтийн дагуу асуудлыг тодруулж, зөвлөлдөхөөр холбогдох улсуудыг урина. Хэрэв ийнхүү зөвлөлдсөнөөр бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэж чадаагүй бол Зөвлөл нь өөрийн зохих шийдвэр болон зөвлөмжийг гаргаж, холбогдох улсуудад өгнө. Хэрэв үүний дараа хэлэлцэн тохиролцогч холбогдох улс нь зөрчлөө арилгах зохих арга хэмжээг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр аваагүй байна гэж Зөвлөлөөс үзвэл эдгээр арга хэмжээг авах хүртэл нь хэлэлцэн тухайн тохирогч улсын энэхүү хэлэлцээрийн дагуу эдлэх эрх болон давуу эрхүүдийг түдгэлзүүлэхээр дээр дурдсан Байгууллагын Чуулганд санал оруулж болно. Чуулган нь гуравны хоёрын саналаар хэлэлцэн тохиролцогч тухайн улсын эрхийг өөрийн шаардлагатай гэж үзсэн хугацаагаар, эсхүл зөрчлийг арилгах холбогдох арга хэмжээг авсан гэж Зөвлөлөөс үзэх хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.

2 дахь хэсэг

Хэлэлцэн тохиролцогч хоёр буюу түүнээс дээш улсын хооронд энэхүү хэлэлцээрийг тайлбарлах, эсхүл хэрэглэх талаар аливаа маргаан үүсэж, түүнийг хэлэлцээний замаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд дээр дурдсан конвенцын XVIII бүлгийн заалтыг хэрэглэх

бөгөөд уг конвенцыг тайлбарлах, эсхүл хэрэглэхэд гарах аливаа маргааныг шийдвэрлэхтэй адил журмыг баримтлана.

3 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацаа нь дээр дурдсан конвенцын хүчин төгөлдөр байх хугацаатай адил байх бөгөөд энэхүү хэлэлцээрийн оролцогч хэлэлцэн тохиролцогч аль ч тал нь АНУ-ы Засгийн газарт мэдэгдлээ өгснөөс хойш нэг жил өнгөрсний дараа энэхүү хэлэлцээрийг цуцалж болох бөгөөд Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар нь тухайн мэдэгдлийн талаар хэлэлцэн тохиролцогч бусад бүх улсад нэн даруй мэдээлнэ.

4 дүгээр зүйл

Дээр дурдсан конвенц хүчин төгөлдөр болохоос өмнө түүнийг дурдсан аливаа эшлэл нь 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон 5 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд Чикаго хотноо 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдөр гарын үсэг зурсан Олон улсын иргэний нисэхийн түр хэлэлцээрээс эшилсэн гэж ойлгох бөгөөд Олон улсын иргэний нисэхийн байгууллага, Чуулган болон Зөвлөл гэж эшилснийг Түр хугацааны олон улсын иргэний нисэхийн байгууллага, Түр чуулган болон Түр зөвлөл гэж тус тус ойлговол зохино.

5 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрт “нутаг дэвсгэр” гэснийг дээр дурдсан конвенцын 2 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлно.

6 дугаар зүйл
Хэлэлцээрт гарын үсэг зурах, түүнийг хүлээн зөвшөөрөх

Дор гарын үсгээ зурсан Чикаго хотноо 1944 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр болсон Олон улсын иргэний нисэхийн бага хуралд оролцсон төлөөлөгчид нь энэхүү хэлэлцээрт ийнхүү гарын үсэг зурахдаа Засгийн газраа төлөөлж энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурж байна гэж үзэх бөгөөд Засгийн газар тус бүр нь энэхүү хэлэлцээр болон түүгээр хүлээлгэсэн үүргийг хүлээн зөвшөөрч байгаагийн нотолгоо болох тухайгаа Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газарт аль болох богино хугацаанд мэдэгдэнэ.

Олон улсын иргэний нисэхийн байгууллагын гишүүн аливаа улс нь энэхүү хэлэлцээр болон түүгээр хүлээлгэсэн үүргийг зөвшөөрсөн тухайгаа Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газарт мэдэгдсэнээр энэхүү хэлэлцээрийг хүлээн зөвшөөрч болох бөгөөд уг мэдэгдэл нь түүнийг Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хүлээн авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Энэхүү хэлэлцээр нь хэлэлцэн тохиролцогч улс тус бүр түүнийг хүлээн зөвшөөрснөөр эдгээр улсын хооронд хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ. Харин түүнээс хойш энэхүү хэлэлцээрийг хүлээн зөвшөөрсөн тухайгаа Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газарт мэдэгдсэн бусад улсын хувьд уг мэдэгдлийг Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хүлээн авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ. Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар нь энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан буюу түүнийг хүлээн зөвшөөрсөн бүх улсад хэлэлцээрийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдлийн огноо болон хүлээн зөвшөөрсөн улс тус бүрийн хувьд хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн огнооны талаар мэдээлнэ.

Дээрхийг нотолж, зохих ёсоор эрх олгогдсон дор дурдсан этгээдүүд өөрсдийн Засгийн газрын нэрийн өмнөөс энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурав.

Энэхүү хэлэлцээрийг Чикаго хотноо 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдөр англи хэлээр байгуулав. Хоорондоо адил хүчинтэй байх энэхүү хэлэлцээрийн англи, франц болон

испани хэлээр бичсэн гарын үсэг зурахад нээлттэй эх бичвэрийг* Вашигтон, ДС-д хадгална. Энэхүү хэлэлцээрийн эх бичвэрүүд нь Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрын архивт хадгалагдах бөгөөд Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар нь уг хэлэлцээрийн баталгаат хуулбарыг энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурах буюу түүнийг хүлээн зөвшөөрөх бүх улсын Засгийн газарт хүргүүлнэ.

162. ХӨДӨЛГӨӨНТ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ОЛОН УЛСЫН БАТАЛГААТ ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ

2001 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр баталж,
*2006 оны 03 дугаар сарын 01-ний өдөр өдөр хүчин төгөлдөр болсон**

Энэхүү конвенцод оролцогч улс нь,

Өндөр өртөг бүхий буюу эдийн засгийн онцгой ач холбогдолтой хөдөлгөөнт тоног төхөөрөмжийг худалдан авах болон ашиглах, тийм тоног төхөөрөмжийг үр дүнтэй ашиглах болон худалдан авахыг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй болохыг ойлгож,

Тэдгээрийг удирдах тодорхой дүрмийг тогтоох замаар эдгээр хэлцэлд дэмжлэг үзүүлэх хөрөнгөөр баталгаажсан санхүүжилт болон лизингийн давуу талыг хүлээн зөвшөөрч,

Тийм тоног төхөөрөмжийн баталгаат эрх нь түгээмлээр хүлээн зөвшөөрөгдөж, хамгаалагдсан байх шаардлагыг хангах нь зайлшгүй чухал болохыг анхааралдаа авч,

Сонирхогч бүх талд өргөн хүрээтэй, эдийн засгийн харилцан ашигтай байдлыг хангахыг хүсч,

Энэхүү дүрэм нь эдгээр хэлцэлд шаардлагатай оролцогч талын бие даасан байдлыг дэмжиж, лизингийн үндсэн дээр болон хөрөнгөөр баталгаажсан санхүүжилтийн зарчмыг тусгасан байх ёстой гэдэгт итгэж,

Тийм тоног төхөөрөмжид хамаарах олон улсын баталгаат эрхийн эрх зүйн хүрээг тогтоох болон энэ зорилгоор олон улсын бүртгэлийн системийг бий болгох шаардлагатай болохыг ухамсарлаж,

Тийм тоног төхөөрөмжид хамаарах, үйлчилж буй конвенцод тунхагласан зорилго, зарчмыг анхааралдаа авч,

Дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиролцов:

I БҮЛЭГ
ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ БОЛОН НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл
Нэр томьёо

Хам сэдэв нь өөрөөр заагаагүй бол, энэхүү конвенцод хэрэглэсэн дор дурдсан нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

(а) “хэлэлцээр” гэж үүргийн гүйцэтгэлийг хангах хэлэлцээр, өмчлөх эрхийг хадгалсан урьдчилсан худалдааны хэлэлцээр болон лизингийн хэлэлцээр;

* Энэхүү хэлэлцээрийг 1944 оны 11 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 7-ны хооронд Чикаго хотноо болсон Олон улсын иргэний нисэхийн бага хурал дээр англи хэлээр байгуулж, түүнд гарын үсэг зурсан болно. Энэхүү хэлэлцээрт дурдсанаар гурван хэлээрх эх бичвэр нь гарын үсэг зурахад нээлттэй бус юм байна.

* Монгол Улс 2006.10.19-нд соёрхон баталсан

a) Чикаго хотноо 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдөр гарын үсэг зурсан Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын III бүлгийн зорилгоор (Бүртгэлийн эрх бүхий байгууллагын нэр) зохицуулагдан (агаарын хөлгийн бүртгэгчийн нэр)-аас агаарын хөлгийн бүртгэлийн асуудал;
b) агаарын хөлгийг /улсын нэр/ улсаас экспортлох болон бодит шилжүүлэлт хийх.

ii. Эрх бүхий тал, эсхүл хувь хүн нь (i) дэд хэсэгт дурдсан зүйлд бичгээр шаардсанаар гарын үсэг зурагчдын зөвшөөрөлгүйгээр баталгаа хүсч болно. Тус шаардлагын дагуу /улсын нэр/ - ын эрх бүхий байгууллага нь бусад эрх бүхий байгууллагуудтай асуудлыг түргэн шийдэх үүднээс хамтран ажиллана.

Энэ баримт бичгээр үүсэн бий болсон эрх бүхий байгууллагын эрх нь эрх бүхий талуудын бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр солигдохгүй болно.

Та гэрээний шаардлага болон түүний нөхцөлийг хүлээн зөвшөөрч байгаагаа дор байгаа хоосон зайд тохиромжтой хэлбэрээр бөглөж /Бүртгэлийн эрх бүхий байгууллагын нэр/-д тус баримтыг гардуулна уу.

/Эзэмшигчийн нэр / _____

Хүлээн зөвшөөрсөн бөгөөд гардуулсан
/он сар өдөр/

_____
/холбогдох тэмдэглэгээнүүд /

Гарын үсэг зурагчийн нэр:

Гарын үсэг зурагчийн албан тушаал:

Хүлээн авагчийн холбогдох хаягийг заана.

164. ОЛОН УЛСЫН АГААРЫН ТЭЭВРИЙГ ЛИБЕРАЛЧЛАХ ТУХАЙ ОЛОН ТАЛТ ХЭЛЭЛЦЭЭР

2001 оны 05 дугаар сарын 01-ний өдөр баталж,
2001 оны 12 дугаар сарын 21-ний өдөр хүчин төгөлдөр болсон[*]

Энэхүү хэлэлцээрт оролцогч талууд (цаашид “Талууд” гэх),

Хөндлөнгийн оролцоо, зохицуулалт хамгийн бага зах зээл дэх агаарын тээврийн компаниуд хоорондын өрсөлдөөнд суурилсан олон улсын агаарын тээврийн тогтолцоог хөгжүүлэхийг эрмэлзэж,

Олон улсын агаарын тээврийн боломжийг өргөжүүлэхэд түлхэц үзүүлэхийг эрмэлзэж,

Өрсөлдөөнтэй, үр ашигтай олон улсын агаарын үйлчилгээ нь худалдааг нэмэгдүүлж, хэрэглэгчийн ашиг сонирхлыг дээшлүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжихийг хүлээн зөвшөөрч,

Агаарын үйлчилгээг либералчлах яриа хэлэлцээг дэмжихэд оруулж буй Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АЗНДЭЗХА) форумын хувь нэмрийг хүлээн зөвшөөрч,

Зорчигч болон ачаа тээвэрлүүлэгч олон нийтэд төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх боломжийг агаарын тээврийн компаниудад олгох, түүнчлэн агаарын тээврийн компанийн

[*] Монгол Улс 2007.05.04-нд соёрхон баталсан

үнийн шинэчлэл болон өрсөлдөөнт үнийг хөгжүүлэх, нэвтрүүлэх явдлыг дэмжихийг эрмэлзэж,

Олон улсын агаарын тээврийн аюулгүй байдал болон нислэгийн аюулгүй ажиллагааны өндөр төвшинг хангахыг эрмэлзэж, мөн хүний болон өмчийн аюулгүй байдлыг эрсдэлд оруулах, агаарын тээврийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, иргэний нисэхийн аюулгүй байдалд итгэх олон нийтийн итгэлийг бууруулдаг агаарын хөлгийн аюулгүй байдалд эсрэг чиглэсэн үйлдэл болон аюул заналын талаар сэтгэл гүнээ зовниж байдгийг дахин нотолж,

Чикаго хотноо 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдөр гарын үсэг зурахад нээлттэй болсон Иргэний нисэхийн тухай олон улсын конвенцыг тэмдэглэж,

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиров. Үүнд:

1 дүгээр зүйл
Тодорхойлолт

Өөрөөр заагаагүй бол энэхүү хэлэлцээрийн зорилгод дараах нэр томьёо дор дурдсан утгатай байна. Үүнд:

1. “Хэлэлцээр” гэж энэхүү хэлэлцээр, түүний хавсралтууд болон нэмэлтүүд, тэдгээрт оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт;

2. “Агаарын тээвэр” гэж агаарын хөлгөөр зорчигч, тээш, ачаа болон шууданг хамтад нь эсхүл тусад нь эсхүл хөлсөөр, эсхүл төлбөртэй тээвэрлэх нийтийн тээвэр;

3. ”Конвенц” гэж 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Чикаго хотноо гарын үсэг зурахад нээлттэй болсон Иргэний нисэхийн олон улсын конвенц болон түүнд хамаарах:

I. Конвенцын 94(а) дугаар зүйлийн дагуу хүчин төгөлдөр болж энэхүү хэлэлцээрт оролцогч бүх тал соёрхон баталсан аливаа нэмэлт, өөрчлөлт, болон;

II. Конвенцын 90 дүгээр зүйлийн дагуу батлагдсан бөгөөд энэхүү хэлэлцээрт оролцогч бүх талын хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөх аливаа хавсралтууд, тэдгээрт оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт;

4. “Томилогдсон агаарын тээврийн компани” гэж энэхүү хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн заалтын дагуу томилогдож эрх авсан агаарын тээврийн компани;

5. “Бүтэн зардал” гэж захиргааны зохист нэмэлт зардлыг багтаасан үйлчилгээ үзүүлэх зардал;

6. “Олон улсын агаарын тээвэр” гэж хавсралт, нэмэлтэд тодорхойлсончлон нэгээс дээш улсын, эсхүл Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны гишүүн улсын агаарын орон зайгаар дамжин үйлдэж буй агаарын тээвэр;

7. “Үнэ” гэж олон улсын агаарын тээвэртэй холбоотой газрын тээврийг оролцуулан зорчигч, тээш болон/эсхүл ачааг (шууданг оруулахгүй) тээвэрлэх агаарын тээврийн аливаа төлбөр, үнэ эсхүл хураамжийг хэлнэ, үүнд мөн хэрвээ шаардлагатай тохиолдолд агаарын тээврийн компанийн агентууд, тэрхүү онгоцны үнэ, хураамж, төлбөрийг олж авахтай холбоотой нөхцөлийг багтаасан агаарын тээврийн компанийн хураамжийг хэлнэ;

8. “Тээвэрлэлтийн бус зорилготой буулт” гэж зорчигч, тээш, ачаа болон/эсхүл шууданг агаараар тээвэрлэх зорилгоор агаарын хөлгийн бүхээгт авах, буулгахаас өөр зорилгоор үйлдэх буулт;

9. “Нутаг дэвсгэр” гэж аль нэг талын бүрэн эрхт байдал, хэргийн харьяалал, эрх мэдэл, засаг захиргаа, хамгаалал, эсхүл итгэмжлэлд буй хуурай газар болон тэдгээрт хамаарах нутаг дэвсгэрийн ус; болон

10. “Хэрэглэгчид ногдуулах хураамж” гэж нисэх буудлаар үйлчилсэн, агаарын навигацын хангалт хийсэн, эсхүл нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээ хийсэн, төхөөрөмж ашигласан болон тэдгээрт хамаарах үйлчилгээ үзүүлсэн, тоног төхөөрөмжийг ашигласны төлөө агаарын тээврийн компанид ногдуулах хураамж.

2 дугаар зүйл
Эрх олгох

1. Оролцогч тал нь бусад талуудын агаарын тээврийн компаниудад олон улсын агаарын тээврийн үйлчилгээ эрхлэхэд нь зориулж дараах эрхийг олгоно. Үүнд:

a) нутаг дэвсгэр дээгүүр нь буулт хийлгүй нисэж өнгөрөх эрх;
b) нутаг дэвсгэрт нь тээвэрлэлтийн бус зорилготой буулт хийх эрх;
c) томилолтын нөхцөлийн дагуу дор дурдсан маршрут дахь цэгүүдийн хооронд олон улсын агаарын тээврийн хуваарьт, эсхүл захиалгат нислэг үйлдэх эрх:

i. агаарын тээврийн тухайн компанийг томилсон талын нутаг дэвсгэрээс чанад орших цэгүүдээс энэ талын нутаг дэвсгэр, завсрын цэгүүдээр дамжин бусад аливаа талын нутаг дэвсгэр дэх, эсхүл нутаг дэвсгэрийн чанад орших цэг/цэгүүд рүү.
ii. эрх олгож байгаа талын нутаг дэвсгэр дэх аливаа цэг/цэгүүдийн хооронд үйлдэх бүх ачаа тээврийн үйлчилгээ, үйлчилгээнүүд.

d) энэхүү хэлэлцээрт өөрөөр тодорхойлсон бусад эрхүүд.

2. Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол агаарын тээврийн томилогдсон компани бүр өөрийн үзэмжээр:

a) нэг, эсхүл хоёр талдаа нислэг үйлдэх;
b) нэг агаарын хөлгийн нислэгт нислэгийн өөр өөр дугаар хослуулан хэрэглэх;
c) талуудын хилийн доторх, завсрын, хилийн чанад дахь болон талуудын нутаг дэвсгэр дэх цэгүүдэд тогтоосон маршрутаар аль ч хэлбэрээр ямар ч хувилбараар нислэг үйлдэх;

d) аль ч цэг эсхүл цэгүүдэд үйлдэх буултыг алгасах;
e) тогтоосон маршрут дахь аль ч цэгт өөрийн агаарын хөлгийн аль ч нислэгийг өөрийн агаарын хөлөгт шилжүүлэх;

f) хилийн цаадах цэгүүд болон нутаг дэвсгэр дээрээ байгаа аливаа цэгүүдийн хооронд агаарын хөлөг сольж, эсхүл солилгүй, эсхүл нислэгийн дугаар өөрчлөх эсхүл өөрчлөлгүй нислэг үйлдэх, түүнчлэн дээрх нислэгүүдийг шууд нислэг хэмээн үзэж, олон нийтэд сурталчлах;

g) аль ч талын нутаг дэвсгэрийн дотор, эсхүл нутаг дэвсгэрийн гадна буйгаас үл хамааран аль ч цэгт буулт хийх;

h) аливаа бусад талын нутаг дэвсгэрээр дамжин нислэг үйлдэх;

i) Тухайн хөдөлгөөн эхэлсэн цэгээс үл хамааран хөдөлгөөнийг ижил агаарын хөлөгт нэгтгэх;

энэхүү Хэлэлцээрийн дагуу нислэгийн чиглэл болон газар зүйн хязгаарлалтгүйгээр тээвэр хийх аливаа эрхээ алдалгүй үйлдэж болно.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн заалт нь агаарын тээврийн компанийг томилсон талын нутаг дэвсгэр дэх цэгт үйлчилнэ гэсэн шаардлагад хамаарна. Үүнд зөвхөн ачааны тээврийг хамааруулахгүй.

4. Дээр дурдсан маршрутын дагуух аливаа хэсэг (сегмент) буюу хэсгүүдэд (сегментүүд) аливаа томилогдсон агаарын тээврийн компани нь маршрутын аль ч цэгт хөлгийн төрөл, тоог хязгаарлалтгүй өөрчлөх эрхтэйгээр нисэн гарах чиглэлд дээр дурдсан цэгээс чанад дахь тээвэрлэлтийг агаарын тээврийн компанийг томилсон талын газар нутгаас эхлэлтэй тээвэрлэлтийн үргэлжлэл гэж үзэх, нисэн ирэх чиглэлд тухайн агаарын тээврийн компанийг томилсон талын газар нутаг уруу үйлдэж буй тээвэрлэлтийг дээр дурдсан цэгүүдийн чанадад орших цэгүүдээс эхлэлтэй тээвэрлэлтийн үргэлжлэл гэж үзэн бүх төрлийн ачааны тээвэрлэлтээс бусад төрлийн олон улсын нислэг үйлдэж болно.

5. Энэхүү хэлэлцээрийн ямар ч заалт нь аль нэг талаас томилсон агаарын тээврийн компани, эсхүл агаарын тээврийн компанид нөгөө талын нутаг дэвсгэрт зорчигчид, тэдгээрийн тээш, ачаа, эсхүл шууданг хөлсөөр тээвэрлэх, болон нөгөө талын нутаг дэвсгэр дэх нэг цэгээс нөгөө цэг рүү нислэг хийх эрх олгоогүй гэж үзнэ.

3 дугаар зүйл

Агаарын тээврийн байгууллагыг томилох, эрх олгох

1. Энэхүү хэлэлцээрийн дагуу аливаа тал нь олон улсын агаарын тээвэр эрхлэх хүссэн тооны компанийг томилох, ийм томилолтуудаа цуцлах буюу өөрчлөх эрхтэй. Эдгээр томилолтын талаар дипломат шугамаар холбогдох талуудад бичгээр буюу холбогдох бусад шугамаар мэдэгдэх бөгөөд эх хадгалагчид мөн мэдэгдэнэ.

2. Шаардагдах загвар, маягтын дагуу үйл ажиллагаа эрхлэх эрх болон техникийн зөвшөөрөл олгохдоо аливаа тал нь томилогдсон компанийн мэдүүлгийг хүлээн авч дараах нөхцөлийг хангасан тохиолдолд холбогдох журмын дагуу аль болох богино хугацаанд зохих эрх болон зөвшөөрлийг цаг алдалгүй олгоно. Дараах нөхцөл гэдэгт:

a) агаарын тээврийн компанийг томилсон тал, эсхүл тухайн талын иргэд, эсхүл хоёулаа агаарын тээврийн тухайн компанийн үйл ажиллагаанд үр нөлөөтэй хяналт тавьдаг бол;

b) агаарын тээврийн компанийг томилсон талын нутаг дэвсгэрт агаарын тээврийн компани нь байгуулагдсан, эсхүл үндсэн үйл ажиллагаа явуулдаг газартай бол;

c) агаарын тээврийн компани нь гаргасан өргөдлийг хянах талын эсхүл олон улсын агаарын тээврийн үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай хууль тогтоомж, дүрэм журамд дурдагдсан нөхцөлийг хангаж чадахуйц чадамжтай бол;

d) агаарын тээврийн компанийг томилсон тал нь 6 дугаар зүйл (Аюулгүй ажиллагаа) болон 7 дугаар зүйл (Нисэхийн аюулгүй байдал) заалтуудыг дагаж мөрддөг бол.

3. 2 дугаар зүйлийг үл харгалзан, томилгоо хүлээн авагч тал нь нөгөө талаас томилсон агаарын тээврийн компанийн бодит хувь эзэмшигч нь өөрийнхөн харьяатынх бол нөгөө талаас томилсон агаарын тээврийн компанид эрх, зөвшөөрөл олгох шаардлагагүй.

4. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу үйл ажиллагаа явуулах эрх олгож буй талууд тухайн шийдвэрийнхээ талаар эх хадгалагчид мэдэгдэнэ.

5. Энэхүү хэлэлцээрийн ям ар ч заалт томилогдсон агаарын тээврийн компанийн өмчлөл, эзэмших болон түүнд хяналт тавихтай холбоотой аливаа талын хууль тогтоомж, дүрэм журамд нөлөөлөхгүй. Энэ зүйлийн 2 болон 3 дахь хэсгийн дагуу нөгөө талаас хийх тухайн томилгоог баталгаажуулна.

4 дүгээр зүйл
Эрх хүчингүй болгох

1. Аливаа тал дараах тохиолдолд нөгөө талын томилсон агаарын тээврийн компанийн үйл ажиллагаа явуулах эрх, эсхүл техникийн зөвшөөрлийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх, түр хүчингүй болгох, хязгаарлах, эсхүл түүнд дараах нөхцөлийг тавих эрхтэй. Үүнд:

a) тухайн агаарын тээврийн компанийн хүчин төгөлдөр хяналтыг томилсон тал, түүний харьяат, эсхүл хоёулаа хариуцаагүй бол;
b) эхний тал тухайн компанийн бодит хувь эзэмшигч нь өөрийнхөн харьяатынх болохыг тодорхойлсон бол;

c) агаарын тээврийн компанийг томилсон талын нутаг дэвсгэрт агаарын тээврийн компани нь байгуулагдаагүй, эсхүл үндсэн үйл ажиллагаа явуулдаг газаргүй бол;

d) тухайн агаарын тээврийн компани энэхүү хэлэлцээрийн 5 дугаар зүйлд (Хууль тогтоомжийн хэрэглээ) заасан хууль, дүрэм журмыг дагаж мөрдөж чадаагүй; эсхүл

e) нөгөө тал 6 дугаар зүйлийн (Аюулгүй ажиллагаа) заалтаар тогтоосон стандартад хяналт тавьж, мөрдүүлээгүй эсхүл бол.

2. Энэ зүйлийн 1(b) буюу 1(c) дэд хэсэгт заасныг биелүүлэхгүй байх явдлаас цаашид урьдчилан сэргийлэх үүднээс нэн даруй хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гарахаас бусад тохиолдолд энэ зүйлийн заалтаар тогтоогдсон эрхийг зөвхөн агаарын тээврийн компанийг томилсон нөгөө талтай зөвлөлдсөний дараа эдэлнэ.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу агаарын тээврийн компани, эсхүл компаниудын үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, түр хүчингүй болгох, хязгаарлах, эсхүл нөхцөл тавих эрхээ хэрэгжүүлж буй тал энэ үйл ажиллагааныхаа талаар эх хадгалагчид мэдэгдэнэ.

4. Энэ зүйлийн аль ч заалт 7 дугаар зүйл (Нисэхийн аюулгүй байдал)-ийн заалтын дагуу нөгөө талын агаарын тээврийн компани, компаниудын үйл ажиллагаа явуулах эрх болон техникийн зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, түр хүчингүй болгох, хязгаарлах, эсхүл нөхцөл тавих аливаа талын эрхийг хязгаарлахгүй.

5 дугаар зүйл
Хууль тогтоомжийн хэрэглээ

1. Аливаа талын нутаг дэвсгэрт нэвтрэх, нутаг дэвсгэрт нь байх болон нутаг дэвсгэрээс нь гарахад мөрддөг агаарын хөлгийн ашиглалт, навигацид хамаарах хууль, тогтоомжийг нөгөө талын томилсон агаарын тээврийн компаниуд мөрдөнө.

2. Аливаа талын нутаг дэвсгэрт нэвтрэх, нутаг дэвсгэрт нь байх болон нутаг дэвсгэрээс нь гарахад агаарын хөлөг дэх зорчигч, нисэх баг, эсхүл ачааг нутаг дэвсгэртээ оруулах, гаргахдаа мөрддөг хууль тогтоомж, журмууд (тухайлбал, хилээр нэвтрэх, зөвшөөрөл олгох, нисэхийн аюулгүй байдал, цагаачлал, паспорт, гаалийн болон хорио цээрийн албаны ажиллагаанд хамаарах журам, эсхүл шуудангийн хувьд шуудан тээврийн журам)-ыг нөгөө талын агаарын тээврийн компани болон зорчигчид, нисэх баг, эсхүл ачаа тээвэрлэгч эсхүл тэдгээрийн нэрийн өмнөөс дагаж мөрдөнө.

3. Аливаа тал олон улсын агаарын тээврийн ижилхэн үйлчилгээ үзүүлж буй өөрийн, эсхүл нөгөө талаас томилсон агаарын тээврийн компанид өөрийн орны гааль, цагаачлал болон хорио цээрийн дүрэм журмын хувьд давуу тал олгохгүй.

4. Аливаа талын нутаг дэвсгэрээр шууд дамжин нислэг хийх зорчигчид, тэдгээрийн тээш болон ачаанд нисэхийн аюулгүй байдал, мансууруулах бодисын хяналт, хууль бусаар хил нэвтрэх буюу онцгой нөхцөл байдлаас бусад үед нисэх буудлын зориулалтын талбайд үзлэг хийхгүй.

6 дугаар зүйл
Аюулгүй ажиллагаа

1. Энэхүү хэлэлцээрт дурдсан агаарын тээвэр эрхлүүлэхээр нөгөө талаас олгосон, эсхүл хүчин төгөлдөр гэж тооцсон, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ, тусгай зөвшөөрлийг эдгээр гэрчилгээ, тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлага нь Конвенцын дагуу тогтоосон хамгийн доод стандартыг хангасан хэмээн тооцож хүчинтэй болохыг хүлээн зөвшөөрнө. Гэсэн хэдий ч, аливаа тал нь өөрийн нутаг дэвсгэр дээгүүр нь үйлдэх нислэгийн хувьд нөгөө талаас өөрийн харьяатад олгосон, эсхүл хүчин төгөлдөр гэж тооцсон тусгай зөвшөөрөл, гэрчилгээг хүчин төгөлдөр хэмээн хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж болно.

2. Аливаа тал нь агаарын навигацын тоног төхөөрөмж, нисэх бүрэлдэхүүн, агаарын хөлөг болон агаарын тээврийн томилогдсон компанийн үйл ажиллагаатай холбогдуулан нөгөө талын мөрддөг, аюулгүй ажиллагааны стандартад хамаарах асуудлаар зөвлөлдөх хүсэл тавьж болно. Ийм зөвлөгөөний дагуу эхний тал нөгөө талыг дээр дурдсан зүйлийн хүрээнд Конвенцын дагуу тогтоосон хамгийн доод стандарттай дүйцэхүйц аюулгүй ажиллагааны стандарт, шаардлагыг хангаж ажиллах, мөрдүүлж чадахгүй байгааг олж мэдвэл, нөгөө талдаа эдгээр илэрсэн асуудлыг болон хамгийн доод стандартыг хангахад шаардлагатай алхмуудын талаар мэдэгдэх бөгөөд тухайн тал зохих шаардлагатай засах арга хэмжээг авна. Нөгөө тал дурдсан шаардлагатай засах арга хэмжээг тодорхой хугацааны дотор авч хэрэгжүүлээгүй бол тухайн талын томилсон агаарын тээврийн компанид олгосон үйл ажиллагаа эрхлэх эрх, техникийн зөвшөөрлөө түдгэлзүүлэх, хүчингүй болгох, түр хүчингүй болгох, эсхүл хязгаарлах, эсхүл нөхцөл тавих эрхээ эхний тал эдэлнэ.

7 дугаар зүйл
Нисэхийн аюулгүй байдал

1. Олон улсын эрх зүйгээр хүлээсэн эрх, үүргийнхээ дагуу, иргэний нисэхийн аюулгүй байдлыг хууль бус үйлдлээс хамгаалах талаар харилцан хүлээсэн үүрэг нь энэхүү

хэлэлцээрийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болохыг талууд дахин нотолж байна. Олон улсын эрх зүйгээр хүлээсэн түгээмэл эрх, үүргээр үл хязгаарлагдан, ялангуяа 1963 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр Токио хотноо байгуулсан Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенц, 1970 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Гааг хотноо байгуулсан Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенц, 1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Монреал хотноо байгуулсан Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенц болон 1988 оны 2 дугаар сарын 24-ний өдөр Монреал хотноо байгуулсан Олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудалд хүч хэрэглэсэн хууль бус үйлдлийг хориглох тухай протоколын заалтуудыг талууд дагаж мөрдөнө.

2. Аливаа тал иргэний агаарын тээврийн хөлгийг хууль бусаар булаан авах, эдгээр хөлөг, тэдгээрийн зорчигч, нисгэх баг болон нисэх буудал, агаарын навигацын төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, иргэний агаарын навигацын аюулгүй байдлын эсрэг чиглэсэн аливаа аюул заналыг харилцан мэдээлэх зэрэг шаардлагатай бүхий л туслалцааг нөгөө талын хүсэлтийн дагуу үзүүлнэ.

3. Бусад талтай харилцах харилцаандаа аливаа тал нисэхийн аюулгүй байдлын стандарт, Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас тогтоосон болон Конвенцын хавсралтад заасан зохих зөвлөмжийн заалтуудад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах бөгөөд өөрийн улсад бүртгэлтэй агаарын хөлөг ашиглагчид бизнесийн үндсэн үйл ажиллагаа нь явагддаг эсхүл өөрийн газар нутагт байнга оршин суудаг төлөөлөгчийн газартай агаарын хөлөг ашиглагчид болон өөрийн нутаг дэвсгэр дэх нисэх буудлын үйл ажиллагаа эрхлэгчдээс агаарын тээврийн аюулгүй байдлын дээрх заалтуудыг мөн мөрдөн ажиллахыг шаардана.

4. Аливаа тал нь бусад талуудын холбогдох нутаг дэвсгэрт нэвтрэх, гарах, байх үед мөрдөх аюулгүй байдлын нөхцөлүүдийг судлах болон аливаа тал нь өөрийн нутаг дэвсгэрт байгаа агаарын хөлгийг хамгаалах, онгоцонд суухаас өмнө болон суулгах үеийн зорчигчид, нисгэх баг, тэдний тээш, гартаа авч яваа зүйлс, ачаа болон агаарын хөлгийн нөөцийг шалгахтай холбоотой зохих шаардлагатай арга хэмжээг бүрэн авсан байх нөхцөлийг баталгаажуулна. Тодорхой аюул заналхийллийн эсрэг аюулгүй байдлын тусгай арга хэмжээ авах талаар бусад талаас тавьсан аливаа хүсэлтийг нааштайгаар хүлээн авна.

5. Агаарын хөлгийг хууль бусаар булаах, эсхүл зорчигчид, нисгэх баг, агаарын хөлөг, нисэх буудал, түүнчлэн агаарын навигацын төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн хууль бус үйлдэл гарсан, эсхүл ийм үйлдлийн аюул тулгарсан тохиолдолд талууд дээрх үйлдэл буюу аюул заналыг шуурхай, аюулгүй таслан зогсоохын тулд харилцаа холбооны дэмжлэг үзүүлэх болон бусад зохист арга хэмжээ авах замаар харилцан туслалцаа үзүүлнэ.

6. Энэ зүйлийн нисэхийн аюулгүй байдлын заалтуудыг нөгөө тал гажуудуулсан гэж үзэх хангалттай шалтгаан үндэслэл аль нэг талд байвал тухайн талын нисэхийн удирдах байгууллага нөгөө талын нисэхийн удирдах байгууллагаас нэн даруй зөвлөлдөх талаар хүсэлт гаргаж болно. Ийм хүсэлт гаргаснаас хойш 15 хоногийн дотор уг асуудлыг сэтгэлд ханамжтай тохиролцоонд хүрч чадаагүй бол тухайн хүсэлт нь нөгөө талын агаарын тээврийн компани, эсхүл компаниудад олгосон үйл ажиллагаа эрхлэх эрх, техникийн зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах, түр хүчингүй болгох, хязгаарлах, эсхүл нөхцөл тавих үндэслэл болно. Онцгой тохиолдолд, дээр дурдсан 15 хоногийн хугацаа дуусахаас өмнө аль нэг тал түр зуурын арга хэмжээ авч болно.

7. Энэ зүйлийн 6 дугаар заалтын дагуу агаарын тээврийн компани, эсхүл компаниудад олгосон үйл ажиллагаа эрхлэх эрх, техникийн зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах, түр хүчингүй болгох, хязгаарлах, эсхүл нөхцөл тавих эрхээ хэрэгжүүлсэн аливаа тал уг үйлдлийнхээ талаар эх хадгалагчид мэдэгдэнэ.

8 дугаар зүйл
Худалдааны боломжууд

1. Аливаа талын агаарын тээврийн компаниуд нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

a) бусад талын нутаг дэвсгэрт агаарын тээврийг хөгжүүлэх болон худалдаалах зорилгоор төлөөлөгчийн газруудаа байгуулах;
b) бусад талын нутаг дэвсгэрт өөрөө шууд, эсхүл агаарын тээврийн компани төлөөлөгчөөрөө дамжуулан үзэмжээрээ агаарын тээврийн худалдаа хийх. Агаарын тээврийн компани өөрийн тээврийн үйлчилгээгээ худалдах эрхтэй бөгөөд ямар ч этгээд уг үйлчилгээг тухайн орны үндэсний болон чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авах боломжтой байна;
c) нутагт дэвсгэрт явуулсан үйл ажиллагааны зарлагаасаа үлдсэн орлогоо шаардлагатай үедээ салбараараа дамжуулан өөрийн улс уруу хөрвүүлэх, гуйвуулах эрхтэй. Хөрвүүлэг, гуйвуулгыг тухайн гуйвуулгад мөрдөх солилцооны ханшаар, тээвэрлэгчээс гуйвуулга хийлгэхээр мэдүүлэг эхлэн гаргасан өдөр нь аливаа хязгаарлалт, үүнтэй уялдах татварүйгээр хийхийг зөвшөөрнө; түүнчлэн
d) Бусад талын нутаг дэвсгэрт орон нутгийн зардал, түүнчлэн шатахуун худалдан авсан төлбөрөө тухайн талуудын үндэсний валютаар хийх. Аливаа тал агаарын тээврийн компаниуд төлбөрөө нөгөө талын нутаг дэвсгэрт үндэсний валютын талаарх журмын дагуу чөлөөтэй хөрвөх валютаар хийх.

2. Аливаа талын агаарын тээврийн томилогдсон компаниуд нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

a) нутаг дэвсгэрт нь нэвтрэх, суурин байх, ажил эрхлэхтэй холбоотой нөгөө талуудын хууль тогтоомжийн дагуу агаарын тээврийн үйлчилгээ эрхлэхэд шаардагдах удирдлага, худалдаа, техник, ашиглалт болон мэргэжлийн бусад ажилтнуудыг бусад талуудын нутаг дэвсгэрт оруулах, суурьшуулах эрхтэй;
b) бусад талуудын нутаг дэвсгэрт газрын үйлчилгээ (“өөрийн үйлчилгээ”)-г өөрөө эрхлэх, эсхүл үзэмжээрээ ийм төрлийн үйлчилгээг бүрнээр нь, эсхүл хэсэгчлэн үзүүлэхээр өрсөлдөгч агентуудын дотроос сонгон эрхлүүлэх эрхтэй. Энэ эрхийг зөвхөн нисэх буудлын аюулгүй ажиллагааны хангалттай холбогдон гарах зайлшгүй мөрдөх шаардлагын дагуу хэрэгжүүлнэ. Агаарын тээврийн бүх компаниуд газрын үйлчилгээ эрхлэх ижил тэгш боломжтой болсон, хураамж нь үзүүлсэн үйлчилгээний үнэнд суурилсан, өөрөө эрхлэх үйлчилгээг ийм үйлчилгээтэй төрөл, чанараар нь харьцуулж болох төвшинд хүрсэн нөхцөлд компанийн өөрөө эрхлэх үйлчилгээний асуудлыг тавьж болно; мөн
c) тогтоосон маршрутаар нислэг үйлдэж буй, эсхүл олгосон зөвшөөрлийн дагуу үйлчилгээ үзүүлэхдээ, тодорхойлон тогтоосон агаарын зайн ашиглалт, аяллын дугаар хамтарч ашиглах, түрээсийн гэрээгээр ашиглах зэрэг маркетингийн хамтын ажиллагаанд дараах байгууллагатай орж болно. Үүнд:

i) аль нэг талын агаарын тээврийн компани, эсхүл компаниудтай;
ii) аливаа улсын эсхүл энэхүү хэлэлцээрт нэгдэн ороогүй боловч нэмэлт хавсралтанд тодорхойлсон АЗНДЭЗХА-ны эдийн засгийн гишүүн аливаа улсын агаарын тээврийн компани, эсхүл компаниудтай; түүнчлэн
iii) аливаа улсын эсхүл энэхүү хэлэлцээрт нэгдэн ороогүй боловч нэмэлт хавсралтанд тодорхойлсон АЗНДЭЗХА-ны эдийн засгийн гишүүн аливаа улсын газрын тээврийн үйлчилгээ эрхлэгч этгээд эсхүл этгээдүүдтэй

дээрх хамтын ажиллагаанд оролцогч бүх талууд зохих ёсны зөвшөөрөл эрхтэй байх бөгөөд тийм ажиллагаанд шаардагдах шаардлагуудыг хангасан байх ёстой.

3. Энэхүү хэлэлцээрийн бусад аливаа заалтуудыг үл харгалзан талуудын агаарын тээврийн компани болон ачаа тээвэрлэлт шууд бус эрхлэгчид хязгаарлалтгүйгээр нөгөө талын нутаг дэвсгэр дэх аливаа цэг рүү болон цэгээс, түүнчлэн гаалийн албаа бүхий нисэх буудал руу болон буудлаас, олон улсын агаарын тээвэр хийхтэй холбогдуулан ачаа тээвэрлэхээр аливаа газрын тээврийн хэрэгсэл авч ажиллуулахыг зөвшөөрөх бөгөөд боломжтой нөхцөлд мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн дагуу ачаа тээвэрлэх эрх эдэлнэ. Дээрх ачааг газраар, эсхүл агаараар тээвэрлэж буйгаас үл хамааран нисэх буудлын гаалийн талбайд нэвтрүүлэн гаалийн үзлэгт оруулна. Агаарын тээврийн компани газрын тээврээ өөрсдөө, эсхүл газраар тээвэрлэгч өөр байгууллага болон агаарын тээврийн бусад компанитай гэрээ байгуулан тэдний ашиглаж буй газрын тээврийн хэрэгслээр, эсхүл агаарын ачаа тээвэр шууд бус эрхлэгчдээр дамжуулан гүйцэтгүүлэхээр сонгож болно. Ачаа тээврийн ийм олон хувилбарт үйлчилгээг агаар газрын хосолсон тээврийн нэгдсэн нэг үнээр, тээвэрлэгч энэ төрлийн тээврийн хувьд төөрөгдөл үүсгэхгүй байхаар зохион байгуулж болно.

9 дүгээр зүйл

Гаалийн хураамж, төлбөрүүд

1. Аливаа талын нутаг дэвсгэрт хүрэлцэн ирсэн нөгөө талаас томилогдсон агаарын тээврийн компанийн, эсхүл компаниудын олон улсын үйлчилгээндээ ашиглаж байгаа агаарын хөлөг, уг хөлгийн байнгын тоноглол, газрын үйлчилгээний тоног төхөөрөмж, шатахуун, тослох материал, техникийн засварын жижиг эд ангиуд, сэлбэг хэрэгсэл (хөдөлгүүрийг оролцуулан), хөлгийн бүхээг дэх нөөц (нислэгийн хугацаанд зорчигчдод худалдах, тэдэнд үйлчлэхэд зориулсан хязгаарлагдмал тооны хүнс, ундааны зүйл, ликёр, тамхи болон бусад бүтээгдэхүүн зэргийг оролцуулахын зэрэгцээ нэр төрлийг үүгээр үл хязгаарлана) болон зөвхөн олон улсын агаарын тээвэр үйлдэж буй агаарын хөлгийн ашиглалт, үйлчилгээнд зориулах, эсхүл хэрэглэсэн бусад зүйлийг импортын хязгаарлалтууд, өмчид ногдуулах татвар, үндсэн хөрөнгийн ногдол хураамж, гаалийн татвар, акцизийн татвар болон (i) үндэсний эрх бүхий, эсхүл төв байгууллагаас ногдуулдаг; болон (ii) дээрх тоног төхөөрөмж болон хангалтын зүйлс агаарын хөлгийн бүхээгт үлдэх нөхцөлд үзүүлсэн үйлчилгээний үнэ тарифт үндэслээгүй болон эдгээртэй төстэй бүхий л татвар, хураамжаас харилцан адил байх зарчмын үндсэн дээр чөлөөлнө.

2. Үйлчилгээ хийсний төлбөр хураамжаас бусад энэ зүйлийн 1 дэх заалтад дурдан заасан татвар, ногдол, хураамж, төлбөрөөс дараах зүйлийг мөн харилцан адил байх зарчмын үндсэн дээр чөлөөлнө. Үүнд:

a) аль нэг талын агаарын тээврийн компани олон улсын агаарын тээвэртээ ашиглаж буй алсын аялалд гарсан агаарын хөлөгтөө хэрэглэхээр нөгөө талуудын нутаг дэвсгэрт зохистой хязгаарын дотор оруулж ирсэн, эсхүл нутаг дэвсгэрт нь хангалт хийсэн нөөцийг нутаг дэвсгэр дээр нь хангалт хийсэн тухайн талын нутаг дэвсгэр дээгүүр үйлдэх нислэгийн тэр хэсэгт ашиглах байсан ч;

b) аль нэг талын агаарын тээврийн компани олон улсын агаарын тээвэрт ашиглаж буй агаарын хөлгийн техникийн үйлчилгээ, арчилгаа болон засварт зориулан нөгөө талуудын нутаг дэвсгэрт оруулж ирсэн газрын үйлчилгээний тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгсэл (хөдөлгүүрийг оролцуулан);

c) аль нэг талын агаарын тээврийн компани олон улсын агаарын тээвэртээ ашиглаж буй агаарын хөлөгтөө хэрэглэхээр нөгөө талуудын нутаг дэвсгэрт оруулж ирсэн, эсхүл нутаг дэвсгэрт нь хангалт хийсэн шатахуун, тослох материал, техникийн засварын жижиг эд ангиудыг нутаг дэвсгэр дээр нь хангалт хийсэн тухайн талын нутаг дэвсгэр дээгүүр үйлдэх нислэгийн тэр хэсэгт ашиглах байсан ч; түүнчлэн

d) аль нэг талын агаарын тээврийн компани нөгөө талуудын нутаг дэвсгэрт зохистой хязгаарын дотор оруулж ирсэн, эсхүл нутаг дэвсгэрт нь хангалт хийсэн мэдээлэл сурталчилгааны материалыг нутаг дэвсгэр дээр нь хангалт хийсэн тухайн талын нутаг дэвсгэр дээгүүр үйлдэх нислэгийн тэр хэсэгт ашиглах байсан ч.

3. Энэ зүйлийн 1 болон 2 дахь хэсгийн заалтад дурдсан тоног төхөөрөмж, хангалтын зүйлсийг зохих эрх бүхий байгууллагын хяналт, ажиглалтын дор хадгалуулах шаардлагыг тавьж болно.

4. Аль нэг талаас томилогдсон агаарын тээврийн компани нөгөө талаас ногдуулдаг татвар хураамжаас чөлөөлөгдөх эрхийг мөн адил эдэлдэг агаарын тээврийн өөр компаниас энэ зүйлийн 1 болон 2 дахь хэсгийн заалтад дурдсан зүйлсийг нөгөө тал эсхүл талуудын нутаг дэвсгэрт зээлээр, эсхүл шилжүүлэн авахаар тохиролцвол энэ зүйлийн заалтын дагуу татвар хураамжаас чөлөөлөгдөж болно.

10 дугаар зүйл
Ашиглагчид ногдуулах хураамж

1. Аливаа талын хураамж ногдуулах эрх бүхий байгууллага, эсхүл этгээдээс нөгөө талын агаарын тээврийн компанид ногдуулах ашиглалтын хураамж нь шударга, зохистой бөгөөд шударга бусаар алагчлаагүй, ашиглагчдын дунд ангиллаар нь тэгш ногдуулсан байна. Ямар ч тохиолдолд нөгөө талын агаарын тээврийн компанид ногдуулах ашиглалтын аливаа хураамжийг тухайн үед агаарын тээврийн аливаа өөр компанид үзүүлдэг нэн тааламжтай нөхцөлөөс дутуугүй тааламжтай нөхцөлөөр тооцон ногдуулсан байна.

2. Нөгөө талын агаарын тээврийн компанид ногдуулах ашиглалтын хураамжид хураамж ногдуулах эрх бүхий байгууллага, эсхүл этгээдээс тухайн нисэх буудал, нисэх буудлын орчин, агаарын навигацын, нисэхийн аюулгүй байдлын тоног төхөөрөмжөөр хангасан, түүнчлэн нисэх буудлын системийн хүрээнд нисэх буудал дээр үзүүлсэн үйлчилгээний бүрэн үнийг тусгасан байж болох бөгөөд үүнээс хэтрээгүй байна. Ийм хураамжид өмчийн элэгдэл хорогдлыг зохистой хэмжээнд тооцон багтаасан байж болно. Хураамж ногдуулж буй тоног төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээ нь үр дүнтэй, эдийн засгийн ашигтай байх үндсэн дээр гүйцэтгэгдсэн байна.

3. Тал бүр нутаг дэвсгэр дээрээ хураамж ногдуулах эрх бүхий байгууллага, эсхүл этгээд, тоног төхөөрөмжийг нь ашигладаг болон үйлчилгээ авдаг агаарын тээврийн компаниудын хооронд зөвлөлдөөн хийхийг дэмжих бөгөөд хураамж ногдуулах эрх бүхий байгууллага, эсхүл этгээд, агаарын тээврийн компаниуд энэ зүйлийн (1) болон (2) дахь хэсгийн заалтад дурдсан зарчмын дагуу ногдуулж буй хураамж нь үндэслэлтэй эсэхээр нарийн судалгаа хийхэд шаардлагатай гэж үзэж болох тийм мэдээлэл солилцохыг дэмжинэ. Хураамж ногдуулах эрх бүхий байгууллага ногдуулдаг хураамждаа оруулах гэж буй аливаа өөрчлөлтийн тухай зохистой мэдээллийг, ашиглагчдад саналаа илэрхийлэх боломж олгох үүднээс уг өөрчлөлтийг хийхээс өмнө ашиглагчдад хүргэхийг тал бүр дэмжинэ.

4. Аль ч тал:

i)хураамжийг эргэн хянан үзэх, эсхүл нөгөө талаас гаргасан санал гомдлын мөрөөр тодорхой хугацааны дотор түүнийг барагдуулах үүргээ биелүүлээгүй; эсхүл

ii)эргэн хянаж үзсэн ч энэ зүйлийн заалттай үл нийцэх аливаа хураамжийн асуудлыг өөрчлөн шинэчлэх талаар өөрийн эрхийн хүрээнд шаардлагатай

бүх алхмыг хийгээгүй буюу нөхцөлийг өөрчлөөгүй зэрэг шалтгаанаас бусад нөхцөлд энэ зүйлийн заалтыг зөрчсөн асуудлаар 14 дүгээр зүйлийн заалтын дагуу маргаан шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй.

11 дүгээр зүйл
Шударга өрсөлдөөн

1. Талуудаас томилогдсон агаарын тээврийн компаниуд энэхүү хэлэлцээрээр зохицуулагдах олон улсын агаарын тээвэр эрхлэх шударга, тэгш боломжоор хангагдана.

2. Аливаа тал нь агаарын тээврийн томилогдсон компани бүрт зах зээлийн арилжааны ашиг сонирхол дээр суурилан гүйцэтгэж буй олон улсын агаарын тээврийнхээ давтамж, багтаамжийг тодорхойлохыг зөвшөөрнө. Энэ эрхийг эдлэхтэй холбогдуулан аль ч тал нөгөө талуудаас томилогдсон агаарын тээврийн компанийн нислэгийн тоо, давтамж эсхүл нислэгийн тогтмолжилт, эсхүл ашиглаж буй агаарын хөлгийн төрөл эсхүл төрлүүдэд Конвенцын 15 дугаар зүйлийн заалтад нийцүүлэн шаардаж болох гааль, техник, ашиглалтын, эсхүл хүрээлэн буй орчны зэргээс бусад шалтгаанаар хязгаарлалт тавихгүй.

3. Аль ч тал нөгөө талаас томилогдсон агаарын тээврийн компанид нислэгийн багтаамж, давтамж эсхүл хөдөлгөөнтэй холбогдуулан түрүүлж татгалзах болзол, хөөрөлтийн түвшин, татгалзах боломжгүй хураамж эсхүл бусад аливаа шаардлага ногдуулахгүй болно.

4. Аль ч тал нөгөө талаас томилсон агаарын тээврийн компаниас энэ зүйлийн 2 дахь хэсгийн заалтад дурдсан нөхцөлийг бүрдүүлэхэд үл алагчлан хандах зарчмын үндсэн дээр тусгайлан олгогдсон эрхийн дагуу шаардаж болох тэдгээр тохиолдлоос бусад нөхцөлд захиалгат нислэгийн хуваарь, хөтөлбөр, эсхүл нислэг төлөвлөлтийн материалаа танилцуулж батлуулахыг шаардахгүй. Аль нэг тал мэдээллийн зориулалтаар танилцуулга хийлгэхийг хүсвэл танилцуулах материалын бүрдүүлэлтэд тавигдах шаардлага, агаарын тээврийн үйл ажиллагааны дэг, нөгөө талын агаарын тээврийн томилогдсон компани зэрэгт захиргааны ажлын чирэгдэл аль болох бага учруулах ёстой.

5. Талуудын зорчигчдын төлбөр хийх, зорчигчийн гэрээ цуцлах, төлбөрийг эргүүлэн авах эрхийг хамгаалахтай хамаарах асуудлыг зохицуулдаг захиалгат нислэгийн дүрэм журмаар онцгойлон заасан байж болохоос бусад нөхцөлд энэхүү хэлэлцээрийн заалтуудын дагуу аль ч тал энэхүү хэлэлцээрээр тогтоосон олон улсын агаарын тээврийн захиалгат нислэгийг худалдах, эсхүл үйл ажиллагааг хязгаарлах өөрийн хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэглэж болохгүй.

6. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу, талуудын нутаг дэвсгэр дэх аялал жуулчлалын агентлаг эсхүл аялал жуулчлалын компаниудын хэрэглэх суудал захиалгын компьютерын систем (СЗКС)-ээр дамжуулан тал бүрийн агаарын тээврийн компаниуд өөрийн үйлчилгээг шударга, үл алагчлах зарчмын үндсэн дээр зах зээлд нэвтрүүлэх эрхтэй. Үүнээс гадна тал бүрийн суудал захиалгын компьютерын систем (СЗКС)-ийн худалдааны агентууд талуудын нутаг дэвсгэрт үйлчлэх үл алагчлах, үр ашигтай, зах зээлийн сонголтын шууд болон дам нөлөөлөлд орохгүй, бодит үнэлэмж дээр суурилсан СЗКС-ийн талаарх журмыг зөрчихгүйгээр СЗКС-ийг ашиглах эрхтэй байвал талуудын аялал жуулчлалын агентлаг эсхүл аялал жуулчлалын компаниудад өөрийн СЗКС-ийг ашиглуулах боломжийг олгоно. Тухайлбал аль нэг талын агаарын тээврийн аливаа компани нөгөө талын нутаг дэвсгэрт байгаа аялал жуулчлалын агентлаг буюу аялал жуулчлалын компаниудаас санал болгосон СЗКС-д оролцохоор сонговол агаарын тээврийн тухайн компани ийнхүү оролцсоноос үүдэлтэй СЗКС-ээс ногдуулах хураамж нь зах зээлийн үндэслэлгүй (хэрэв аялал жуулчлалын агентлаг эсхүл аялал жуулчлалын компаниудын ашиглаж буй өөр аливаа СЗКС-ээс агаарын тээврийн уг компанид тухайн нутаг дэвсгэрт оролцож байгаагийн хувьд ногдуулах хураамж

нь тухайн оролцооны хувьд өөр талын СЗКС-ээс ногдуулах хураамжтай ижил эсхүл илүү гарахгүй байхыг зах зээлийн үндэслэлтэй хураамж гэж үзнэ) гэж үзэхээс бусад үед агаарын тээврийн тухайн компани нөгөө талын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах СЗКС-д тухайн нөгөө талын нутаг дэвсгэрт байгуулсан аливаа СЗКС-ийн адил бүрэн оролцоно. Аль нэг талын агаарын тээврийн компаниуд болон СЗКС-ийн худалдааны агентууд тухайн талын нутаг дэвсгэр дэх аялал жуулчлалын агентлаг эсхүл аялал жуулчлалын компаниудыг өөр талын СЗКС-ийг ашиглаж байгаа шалтгаанаар алагчилж үзэхгүй.

12 дугаар зүйл
Үнэ

Энэхүү хэлэлцээрийн дагуу хийх агаарын тээвэрт мөрдөх үнийг аль ч тал тогтоохгүй бөгөөд нөгөө талаас түүнийг танилцуулахыг үл шаардах аль нэг талын хууль тогтоомжоор шаарддаг бол мэдээллийн зорилгоор үнийн талаарх мэдээллийг тухайн тал шаардаж болно.

13 дугаар зүйл
Зөвлөлдөөн

Аль ч тал энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх, эсхүл хэрэглэхтэй холбогдолтой асуудлаар бусад нэг эсхүл түүнээс дээш талтай зөвлөлдөх хүсэлт гаргах эрхтэй. Өөрөөр тохиролцоогүй бол уг зөвлөлдөөнийг аль болох түргэн эхлүүлэх бөгөөд нөгөө тал, эсхүл талууд холбогдох асуудлаар хийсэн тайлбар бүхий бичгээр үйлдсэн хүсэлтийг дипломат, эсхүл зохих бусад шугамаар хүлээн авсан өдрөөс хойш жар (60) хоногийн дотор эхлүүлнэ. Зөвлөлдөөн хийх өдрийг тохиролцсон нөхцөлд хүсэлт гаргасан тал үүнийг холбогдох асуудлын хамт бусад бүх талуудад мэдэгдэнэ. Зөвлөлдөөн хийх талууд зөвшөөрсөн тохиолдолд түүнд аль ч тал оролцож болно. Зөвлөлдөөн болж дуусмагц, үр дүнг бүх талуудад мэдэгдэнэ.

14 дүгээр зүйл
Маргааныг шийдвэрлэх

1. Энэхүү хэлэлцээртэй холбогдон гарсан аливаа маргааныг албан ёсны анхны зөвлөлдөөнөөр шийдвэрлээгүй бол шийдвэрлүүлэхээр аль нэг этгээд эсхүл байгууллагад талуудын тохиролцсоны дагуу хандаж болно. Хэрэв маргалдагч талууд тохиролцоонд хүрээгүй бол маргааныг аль нэг талын хүсэлтээр дор дурдсан журмын дагуу арбитрын шүүхэд шилжүүлнэ. Маргааныг арбитрын шүүхэд шилжүүлж байгаа тал маргааны тухай болон түүнийг арбитрын шүүхээр шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан тухайгаа бусад бүх талуудад мэдэгдэнэ.

2. Гурван арбитрчийн бүрэлдэхүүнтэй арбитрын шүүх дараах байдлаар байгуулагдана:

a. Арбитрт хүсэлт гаргасан өдрөөс хойш 30 хоногийн дотор маргалдагч тал бүр нэг арбитрчийг томилно. Эдгээр хоёр арбитрч томилогдсоноосоо хойш 60 хоногийн дотор арбитрын шүүхийн ерөнхийлөгчөөр ажиллах гуравдагч арбитрчийг томилох талаар маргалдагч талууд харилцан тохиролцоно;

b. Дурдсан хугацаанд маргалдагч аль нэг тал өөрийн арбитрчийг томилоогүй, эсхүл энэ хэсгийн (a) дэд хэсгийн заалтын дагуу гуравдагч арбитрч томилогдоогүй бол аль нэг тал шаардлагатай арбитрч эсхүл арбитрчдыг томилуулахаар Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Зөвлөлийн Ерөнхийлөгчид хандан шаардлагатай арбитрч эсхүл арбитрчдыг 30

хоногийн дотор томилуулахаар хүсэлт гаргаж болно. Хэрэв Зөвлөлийн Ерөнхийлөгч маргалдагч аль нэг талын иргэн бол Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Зөвлөлийн дараагийн шатны, дээрх шалтгаанаар эрх нь хязгаарлагдаагүй Тэргүүн Дэд ерөнхийлөгч уг томилолтыг хийнэ.

3. Маргалдагч талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн бүхий арбитрын шүүх энэхүү хэлэлцээрийн дагуу хэргийн харьяаллын хязгаарлалтыг тодорхойлж, шүүх хуралдааны дэгээ тогтооно. Арбитрын шүүх байгуулагдмагц эцсийн шийдвэр гаргатал түр мөрдөх үйл ажиллагааны дэгийн талаар зөвлөмж гаргаж болно. Арбитрын шүүхийн зааварчилга, эсхүл маргалдагч аль нэг талын хүсэлтээр арбитрын шүүхээр хэлэлцэх тухайн асуудал, баримтлах тусгай дэгийг тогтоох бага хурлыг арбитрын шүүхийн гуравдагч арбитрч томилогдсоноос хойш арван таван (15)-аас хойшгүй өдрийн дотор, арбитрын шүүхийн товлосон өдөр хийнэ. Хэрэв маргалдагч талууд эдгээр асуудлаар тохиролцож чадахгүй бол арбитрын шүүх хэлэлцэх тухайн асуудал, баримтлах тусгай дэгийг тогтооно.

4. Маргалдагч талууд өөрөөр тохиролцоогүй, эсхүл арбитрын шүүх өөрөөр тогтоогоогүй бол нэхэмжлэгч тал арбитрын шүүхийн гуравдагч арбитрч томилогдсоноос хойш дөчин тав (45) хоногийн дотор санамж бичиг бэлтгэн ирүүлэх бөгөөд нэхэмжлэгч тал санамж бичиг бэлтгэн ирүүлснээс хойш жар (60) хоногийн дараа хариуцагч тал хариултыг өгнө. Нэхэмжлэгч тал хариуцагч талаас ирүүлсэн хариултад гуч (30) хоногийн дотор хариуг өгөх бөгөөд хариуцагч тал нэхэмжлэгчээс ирүүлсэн хариуг авснаас хойш гуч (30) хоногийн дотор түүний хариуг өгнө. Арбитрын шүүх аль нэг талын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачлагаар талуудаас сүүлчийн хариу авсны дараа арван тав (15) хоногийн дотор хэрэг сонсох хуралдааныг явуулна.

5. Арбитрын шүүх хэрэг сонссоноос хойш гуч (30) хоног, хэрэг сонсох хуралдаан хийгээгүй бол талуудын сүүлчийн хариу өгсөн өдрөөс хойш гаргасан шийдвэрээ бичгээр мэдэгдэхийг эрмэлзэнэ. Шийдвэрийг олонхын саналаар гаргана.

6. Маргалдагч талууд шүүхийн шийдвэрийн талаар тодруулга хийх хүсэлт гаргаж болох бөгөөд аливаа тодруулгыг хүсэлт хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хийнэ.

7. Хоёр буюу түүнээс дээш талын хооронд маргаан гарсан тохиолдолд эдгээр талууд энэ зүйлд дурдсан шүүх ажиллагааны аль нэг, эсхүл аль аль талын үүргийг гүйцэтгэн оролцож болно. Энэ зүйлд дурдсан журмыг дор дурдсанаас бусад үед хэрэглэнэ:

a) 2(a) дэд хэсгийн хувьд маргааны нэг тал болж буй талууд дундаасаа нэг арбитрчийг томилно;
b) 2(b) дэд хэсгийн хувьд маргааны нэг тал болж буй талууд дундаасаа нэг арбитрчийг зөвшөөрөгдсөн хугацаанд томилоогүй бол маргааны нөгөө тал болж буй тал, эсхүл талууд арбитрчийг томилуулахаар 2(b) хэсэгт заасан журмыг хэрэглэж болно; түүнчлэн
c) 3, 4 болон 6 дахь хэсгийн хувьд маргааны аль нэг тал болж буй талууд маргааны нэг талын адил үйл ажиллагаа хэрэгжүүлэх эрхтэй.

8. Маргаанд шууд хамааралтай бусад тал шүүх ажиллагаанд дараах нөхцөлийн дагуу оролцох эрхтэй:

a) шүүх ажиллагаанд оролцож буй тал арбитрын шүүхийн гуравдагч арбитрч томилогдсоноос хойш арван (10) өдрийн дотор ийнхүү хамааралтай болсон тухай арбитрын шүүхэд мэдэгдэж, танилцуулна;
b) арбитрын шүүх аливаа мэдэгдэл бүрийн тухай маргалдагч талуудад мэдээлэх бөгөөд маргалдагч талууд уг мэдээллийг тус бүрдээ хүлээж

авснаас хойш гуч (30) хоногийн дотор арбитрын шүүхэд тухайн талыг энэ хэсгийн дагуу шүүх хуралд оролцуулах эсэх саналаа мэдэгдэнэ. Арбитрын шүүх уг саналуудыг авснаас хойш арван тав (15) хоногийн дотор тухайн талыг шүүх хуралд оролцуулах боломжтой эсэхийг шийдвэрлэнэ;

c) Хэрэв арбитрын шүүх тухайн талыг шүүх хуралд оролцуулах шийдвэр гаргавал оролцох гэж буй тал ийнхүү оролцох болсон тухайгаа энэхүү хэлэлцээрийн бүх талд мэдэгдэх бөгөөд энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан хуваарийн дагуу арбитрын шүүхээс тогтоосон цаг хугацааны хүрээнд оролцох гэж буй тухайн талаас хэрэг сонсох болон шүүх ажиллагааны аливаа дараагийн шатанд оролцоход танилцуулах шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэх талаар арбитрын шүүх үе шаттай арга хэмжээ авна; түүнчлэн

d) Арбитрын шүүхийн шийдвэр нь оролцох гэж буй талын хувьд нэгэн адил хүчин төгөлдөр байна.

9. Арбитрын шүүхийн аливаа шийдвэр, эсхүл тогтоолыг тал бүр үндэснийхээ хууль тогтоомжийн заалтад нийцүүлэн хүчин төгөлдөр болгоно.

10. Арбитрын шүүх гаргасан шийдвэр, эсхүл тогтоолын хуулбарыг маргалдагч талууд, түүний дотор шүүх хуралд оролцогч аливаа талуудад хүргүүлнэ. Арбитрын шүүх гаргасан шийдвэр эсхүл тогтоолын хуулбарыг эх хадгалагчид мөн хүргүүлэх бөгөөд үйл ажиллагааны мэдээллийн нууцлалыг зохих нөхцөлийн дагуу хангана.

11. Маргалдагч талууд, түүний дотор шүүх хуралд оролцогч талууд арбитрын шүүхийн болон арбитрчдын зардал, төлбөрийг тэнцүү хувааж төлнө. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Зөвлөлийн Ерөнхийлөгч энэ зүйлийн 2(b) дэд хэсэгт заасан дэгийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан зардлыг арбитрын шүүхийн зардлын нэгэн хэсэг гэж үзнэ.

15 дугаар зүйл
Бусад хэлэлцээртэй холбогдох

Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болмогц аливаа тал болон бусад талууд хоорондын агаарын тээврийн тухай хоёр талт хэлэлцээр үйлчлэлээ зогсоох бөгөөд энэхүү хэлэлцээр тэдгээрийн хооронд хүчинтэй байх хүртэл дурдсан хэлэлцээр үйлчлэлээ зогсоосон хэвээр байна.

16 дугаар зүйл
Хавсралттай холбогдох нь

Хавсралт нь энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг бөгөөд өөрөөр шууд заагаагүй бол энэхүү хэлэлцээрээс хийх эшлэл нь нэгэн зэрэг түүний хавсралтаас хийх эшлэл болно.

17 дугаар зүйл
Нэмэлт, өөрчлөлт

1. Аль ч тал нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа эх хадгалагчид хүргүүлэх замаар энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Эх хадгалагч тухайн саналыг хүлээж авсны дараа бусад талд дипломат эсхүл зохих бусад шугамаар хүргүүлнэ.

2. Энэхүү хэлэлцээрт дараах журмын дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно:

a) Нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргасан өдөр бүх талын энгийн олонх нь уг саналыг зөвшөөрвөл тухайн саналыг хэлэлцэх хэлэлцээг явуулна;

b) өөрөөр тохиролцоогүй бол нэмэлт, өөрчлөлтийг санал болгож байгаа тал хэлэлцээг өөртөө зохион байгуулах бөгөөд тухайн хэлэлцээг явуулахаар тохиролцсон өдрөөс ер (90)-ээс илүүгүй хоногийн дараа хэлэлцээг эхлүүлнэ. Хэлэлцээнд бүх талууд оролцох эрхтэй;
c) тухайн хэлэлцээнд оролцогч бүх талуудын хамгийн багадаа энгийн олонх нь нэмэлт, өөрчлөлтийг баталбал, эх хадгалагч тухайн нэмэлт, өөрчлөлтийн баталгаат хуулбарыг талуудаар хүлээн зөвшөөрүүлэхээр бэлтгэж, тэдэнд хүргүүлнэ;
d) талуудын энгийн олонх нь хүлээн зөвшөөрсөн тухай бичгээр үйлдсэн мэдэгдлийг эх хадгалагч хүлээн авснаас хойш гуч (30) хоногийн дараа аливаа нэмэлт, өөрчлөлт нь түүнийг хүлээн зөвшөөрсөн талуудын хувьд хүчин төгөлдөр болно; түүнчлэн
e) бусад талын хувьд нэмэлт, өөрчлөлт нь түүнийг хүлээн зөвшөөрсөн тухай бичгээр үйлдсэн мэдэгдлийг эх хадгалагч тухайн талаас хүлээж авсан өдрөөс хойш (30) хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

3. 2 дахь хэсэгт дурдсан журмаас гадна энэхүү хэлэлцээрт дараах журмын дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно:

a) хэрэв нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал гаргах үед бүх тал түүнийг зөвшөөрч батлах тухайгаа дипломат эсхүл холбогдох бусад шугамаар санал гаргаж буй талд бичгээр мэдэгдвэл нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал гаргаж байгаа тал энэ талаар эх хадгалагчид мэдэгдэж, тэрбээр тухайн нэмэлт, өөрчлөлтийн баталгаат хуулбарыг талуудаар хүлээн зөвшөөрүүлэхээр бэлтгэж, тэдэнд хүргүүлнэ; мөн
b) ийнхүү батлагдсан нэмэлт, өөрчлөлт нь түүнийг хүлээн зөвшөөрсөн тухай бичгээр үйлдсэн мэдэгдлийг эх хадгалагч бүх талаас хүлээн авснаас хойш гуч (30) хоногийн дараа бүх талын хувьд хүчин төгөлдөр болно.

18 дугаар зүйл
Хэлэлцээрээс гарах

Аль ч тал хэлэлцээрээс гарах тухай бичгээр үйлдсэн мэдэгдлийг эх хадгалагчид өгөх замаар энэхүү хэлэлцээрээс гарч болно. Тухайн тал гарах тухай мэдэгдлээ гаргаснаас хойш арван хоёр (12) сарын дотор эгүүлж авах талаар эх хадгалагчид бичгээр мэдэгдэхээс бусад тохиолдолд гарах тухай мэдэгдлийг эх хадгалагч хүлээж авснаас хойш арван хоёр (12) сарын дараа тухайн талыг энэхүү хэлэлцээрээс гарсанд тооцно.

19 дүгээр зүйл
Эх хадгалагчийн үүрэг

1. Энэхүү хэлэлцээрийн эх хадгалагчаар Шинэ Зеланд Улсын Засгийн газрыг үүгээр томилж, тэр нь энэхүү хэлэлцээрийн эх хувийг цаашид хадгална.

2. Эх хадгалагч нь энэхүү хэлэлцээр, түүнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт буюу протоколын баталгаат хуулбарыг гарын үсэг зурсан буюу хүлээн зөвшөөрсөн бүх улс, түүнчлэн Хавсралтын дагуу энэхүү хэлэлцээрийн дагуу үүрэг хүлээхээ зөвшөөрсөн АЗНДЭЗХА-ны эдийн засгийн гишүүн орнуудад хүргүүлнэ.

3. Эх хадгалагч нь гарын үсэг зурсан буюу хүлээн зөвшөөрсөн бүх улс, түүнчлэн Хавсралтын дагуу энэхүү хэлэлцээрийн дагуу үүрэг хүлээхээ зөвшөөрсөн АЗНДЭЗХА-ны эдийн засгийн гишүүн орнуудад Хавсралтын дагуу дараах зүйлийг мэдэгдэнэ:

a) 20, 17 дугаар зүйлд заасны дагуу энэхүү хэлэлцээр болон аливаа нэмэлт, өөрчлөлтөөр үүрэг хүлээхээр зөвшөөрсөн тухай болон АЗНДЭЗХА-ны эдийн засгийн гишүүн орнуудаас хавсралтын дагуу энэхүү хэлэлцээрээр үүрэг хүлээснийг зөвшөөрсөн,

эсхүл 17 дугаар зүйлд заасны дагуу аливаа нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгийн талаар;

b) 20 дугаар зүйлийн 2, 3, 4 болон 6 дахь хэсгийн дагуу энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрүүдийн тухай;

c) 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн дагуу энэхүү хэлэлцээрийг хэрэглэхгүй байх талаар хүлээж авсан мэдэгдлийн тухай;

d) 18 дугаар зүйлийн дагуу энэхүү хэлэлцээрээс гарах мэдэгдлийн тухай;

e) 17 дугаар зүйлийн 2 (a) дэд хэсгийн дагуу нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцүүлэх хэлэлцээг эхлүүлэх тухай;

f) 17 дугаар зүйлийн 2 (d), 2 (e) болон 3 (b) дэд хэсгийн дагуу нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрүүдийн тухай; түүнчлэн

g) 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг болон 7 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн дагуу мэдэгдэл хүлээн авсан өдрийн тухай.

4. Энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болсны дараа эх хадгалагч энэхүү хэлэлцээрийг бүртгүүлэх болон хэвлүүлэхээр түүний баталгаат хуулбарыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад, Конвенцын 83 дугаар зүйлийн дагуу Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад тус тус хүргүүлнэ.

5. Эх хадгалагч нь агаарын тээврийн компанийн томилгоо болон энэхүү хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 1 болон 4 дэх хэсэгт заасан үйл ажиллагаа явуулах эрхийн төв бүртгэлийг хариуцан гүйцэтгэнэ.

6. Эх хадгалагч нь энэхүү хэлэлцээрийн 14 дүгээр зүйлд заасан арбитрын шүүхийн аливаа шийдвэр буюу тогтоолын баталгаат хуулбараар талуудыг хангах боломжийг бүрдүүлнэ.

20 дугаар зүйл
Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү хэлэлцээр нь Бруней Даруссалам Улс, Бүгд Найрамдах Чили Улс, Шинэ Зеланд Улс, Бүгд Найрамдах Сингапур Улс болон Америкийн Нэгдсэн Улсын хувьд гарын үсэг зурахад нээлттэй байна.

2. Энэхүү хэлэлцээр нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан дөрвөн улсын хувьд соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх буюу батлах аливаа нөхцөлгүйгээр гарын үсэг зурсан өдөр, эсхүл соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн буюу баталсан тухай баримт бичгийг эх хадгалагчид хадгалуулсан өдрөөс хүчин төгөлдөр болно. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан бүх улсын хувьд гарын үсэг зурсан өдрөөс энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдөр хүртэл энэхүү хэлэлцээрийн нөхцөлийн дагуу үйлчилгээ эрхлэхийг энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурагсад зөвшөөрч болно.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болсны дараа гарын үсэг зурсан аливаа талын хувьд соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн буюу баталсан тухай баримт бичгийг эх хадгалагчид хадгалуулсан өдрөөс энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болно.

4. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болсны дараа 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан нисэхийн аюулгүй байдлын тухай конвенцуудын оролцогч аливаа талын хувьд нэгдэн орох тухай баримт бичгийг эх хадгалагчид хадгалуулснаар энэхүү хэлэлцээрт нэгдэн орж болно.

5. Эх хадгалагчаас нэгдэн орсон тухай баримт бичиг буюу хэлэлцээрээр үүрэг хүлээлгэсэн тухай баримт бичгийг хадгалуулсан тухай талуудад мэдэгдсэн өдрөөс хойш ерэн (90) хоногийн дотор энэхүү хэлэлцээрт нэгдэн орж буй улс, эсхүл Хавсралтын дагуу энэхүү хэлэлцээрийн үүргийг биелүүлэхийг зөвшөөрсөн АЗНДЭЗХА-ны эдийн засгийн аливаа гишүүн орон болон энэхүү хэлэлцээрийн аливаа талын хооронд энэхүү хэлэлцээрийг хэрэглэхгүй бөгөөд тухайн тал болон нэгдэн орж буй улс, эсхүл АЗНДЭЗХА-ны эдийн засгийн аливаа гишүүн орны хооронд түүнийг үл хэрэглэх талаар эх хадгалагчид бичгээр мэдэгдэнэ. Хэлэлцээрт гарын үсэг зурсан улс энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсны дараа түүний үүргийг биелүүлэх тухайгаа илэрхийлэхдээ гарын үсэг зурагч тухайн улс болон энэхүү хэлэлцээрт нэгдэн орсон аливаа улс, эсхүл Хавсралтын дагуу энэхүү хэлэлцээрийн үүргийг биелүүлэхийг зөвшөөрсөн АЗНДЭЗХА-ны эдийн засгийн аливаа гишүүн орны хооронд энэхүү хэлэлцээрийг гарын үсэг зурагч тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болтол түүнийг хэрэглэхгүй байх талаар эх хадгалагчид бичгээр мэдэгдэж болно.

6. Энэхүү хэлэлцээр нь нэгдэн орж буй улс болон энэ зүйлийн 5 дахь хэсгийн дагуу энэхүү хэлэлцээрийг үл хэрэглэх талаар эх хадгалагчид мэдэгдсэн улсаас бусад бүх талын хооронд энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан ерэн (90) хоногийн хугацаа дууссанаас хойш гуч (30) дахь өдөр хүчин төгөлдөр болно.

Гарын үсэг

Дээр дурдсаныг нотолж, өөрсдийн Засгийн газраас олгосон бүрэн эрхийн дагуу энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурав.

Энэхүү хэлэлцээрийг 2001 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Вашингтон хотноо англи, испани, малайз хэлээр үйлдсэн бөгөөд эх бичвэр бүр адил хүчинтэй байна. Гурван хэлээрх эх бичвэрийн хооронд зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

ХАВСРАЛТ

1. Энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болсны дараа энэхүү хавсралтын нэмэлтэд тодорхойлсон Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны форумын (“АЗНДЭЗХА-ны эдийн засгийн гишүүн орон) гишүүн аливаа орон дараах шалгуурыг хангасан нөхцөлд энэхүү хэлэлцээрийн үүргийг биелүүлэх талаар эх хадгалагчид бичгээр үйлдсэн баримтыг хүргүүлж болно:

a) энэхүү хэлэлцээрийн 20 дугаар зүйлд заасан нөхцөлийн дагуу нэгдэн орох шаардлагагүй тухай;
b) энэхүү хэлэлцээрийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан нисэхийн аюулгүй байдлын талаарх конвенцуудыг биелүүлэхээ зөвшөөрч байгаа, эсхүл тухайн конвенцуудыг ямарваа нэгэн байдлаар хэрэглэж байгаа тухай.

2. 1 дэх хэсэгт заасны дагуу энэхүү хэлэлцээрийн үүргийг биелүүлэхийг зөвшөөрсөн АЗНДЭЗХА-ны эдийн засгийн аливаа гишүүн аливаа орон бусад бүх талтай (20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн дагуу энэхүү хэлэлцээрийг хэрэглэхгүй байх талаар мэдэгдэл өгсний дагуу түүнийг үл хэрэглэх аливаа талаас бусад) харилцах харилцаандаа энэхүү хэлэлцээрээр талуудад олгосон бүх эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Аль нэг тал (20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн дагуу энэхүү хэлэлцээрийг хэрэглэхгүй байх талаар мэдэгдэл өгсний дагуу түүнийг үл хэрэглэх аливаа талаас бусад) АЗНДЭЗХА-ны эдийн засгийн гишүүн аливаа оронтой харилцахдаа энэхүү хэлэлцээрээр талуудад олгосон бүх эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Энэ хэсэгт тодорхойлсон эрх, үүрэг нь 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу ерэн (90) хоногийн хугацаа дууссанаас хойш гуч (30) дахь өдөр хүчин төгөлдөр болно.

ХУВААРЬ

Австрали Улс
Бруней Даруссалам Улс
Канад Улс
Бүгд Найрамдах Чили Улс
Бүгд Найрамдах Хятад Ард Улс
Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг Захиргааны Онцгой Бүс Хонконг
Бүгд Найрамдах Индонез Улс
Япон Улс
Бүгд Найрамдах Солонгос Улс
Малайз Улс
Мексикийн Нэгдсэн Улс
Шинэ Зеланд Улс
Папуа Шинэ Гвиней Улс
Бүгд Найрамдах Перу Улс
Бүгд Найрамдах Филиппин Улс
Оросын Холбооны Улс
Бүгд Найрамдах Сингапур Улс
Хятадын Тайвань
Тайландын Хаант Улс
Америкийн Нэгдсэн Улс
Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс

165. ОЛОН УЛСЫН АГААРЫН ТЭЭВРИЙГ ЛИБЕРАЛЧЛАХ ТУХАЙ ОЛОН ТАЛТ ХЭЛЭЛЦЭЭРТ ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

2001 оны 05 дугаар сарын 01-ний өдөр баталж,
2001 оны 12 дугаар сарын 21-ний өдөр хүчин төгөлдөр болсон[*]

2004 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр болсон хэлэлцээний үеэр Олон улсын агаарын тээврийг либералчлах тухай олон талт хэлэлцээрт зөвхөн ачаа тээвэрлэлттэй холбоотой шинэ зүйл нэмж оруулахаар хэлэлцэн тохиролцов. Эх хадгалагч шинээр оруулахаар санал болгож буй 15 bis дугаар зүйлийн баталгаат хуулбарыг бүх талд хүргүүлэв. Нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдлийг Бүгд Найрамдах Сингапур Улсаас (2004 оны 6 дугаар сарын 22-ны өдөр), Америкийн Нэгдсэн Улсаас (2004 оны 7 дугаар сарын 7-ны өдөр), Шинэ Зеланд Улсаас (2005 оны 8 дугаар сарын 31-ний өдөр) болон Бруней Даруссалам Улсаас (2005 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр) тус тус хүлээж авав. Олон улсын агаарын тээврийг либералчлах тухай олон талт хэлэлцээрийн 17 дугаар зүйлийн дагуу нэмэлт, өөрчлөлт нь 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр хүчин төгөлдөр болов.

Уг зүйлийн эх бичвэр нь:

15 bis дугаар зүйл
Зөвхөн агаараар ачаа тээвэрлэхэд хэрэглэх

1. Аливаа улс, эсхүл энэхүү хэлэлцээрийн үүргийг биелүүлэхийг зөвшөөрсөн АЗНДЭЗХА-ны гишүүн эдийн засаг нь нэгдэн орох баримт бичиг, эсхүл хэлэлцээрийн дагуу үүрэг хүлээхээ мэдэгдсэн баримт бичигт энэхүү хэлэлцээрийн нөхцөлийг зөвхөн олон улсын агаарын ачаа тээврийн хувьд л хэрэглэх талаар өөрийн хүсэлтийг тусгаж болно. Тус тохиолдолд энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу зөвхөн олон улсын агаарын ачаа тээврийн

[*] Монгол Улс 2007.05.04-нд соёрхон баталсан